

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. БҮТЭЦ, ОРОН ТОО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх дотоод аудитын нэгжтэй байна.” гэж заасны дагуу Нийслэлийн Засаг даргын 2014 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/156 дугаар захирамжаар “Нийслэлийн Дотоод аудитын алба”-ыг Санхүүгийн аудитын хэлтэс, Гүйцэтгэлийн аудитын хэлтэс, Чанарын хяналтын хэлтэс, Захиргаа, хуулийн хэлтэс гэсэн 4 хэлтэс, 3 ахлах аудитор, 1 ахлах шинжээч, 4 аудитор, 8 шинжээч, 1 ахлах нягтлан бодогчтой нийт 22 албан хаагчтайгаар ажилласан. Нийслэлийн Засаг даргын 2016 оны 08 дугаар сарын 31-ний А/635 захирамжаар байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар өөрчлөгдөж, 18 албан хаагчтайгаар тайлант оныг дуустал ажиллалаа.

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөх, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр нийслэлийн төсөвт байгууллага, нийслэлийн өмчит, нийслэлийн өмч давамгайлсан үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хараат бус хэрэгжүүлэгч агентлаг юм.

Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын эрсдэлийн удирдлага, засаглал, дотоод хяналтын үйл явцыг хараат бус, бие даасан байдлаар үнэлэн дүгнэлт, зөвлөмж өгч, үйл ажиллагааг сайжруулахад манай эрхэм зорилго оршино.

Эрхэм зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг тодорхойлон байгууллагын жилийн болон дунд хугацааны төлөвлөгөөнд тусган нийслэлийн Дотоод аудитын хорооны даргаар батлуулан ажилласан. Үүнд:

1. Аудитын дунд хугацаанд аудитын хамрах хүрээний бүх объектуудад эрсдэлд суурилсан дотоод аудитыг хийн, дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх;
2. Судалгаа шинжилгээ хийн, сургалт явуулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын засаглал, эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр ашгийг дээшлүүлэх зорилгоор арга зүйн зөвлөмжөөр хангах;
3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийг үнэн зөв мэдээллээр ханган, удирдлагын тогтолцоог төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулах.

Байгууллагын дүрмээр хүлээсэн үүрэг, зорилго, зорилтыг хангахын тулд дараах ажлуудыг 2016 онд хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Нийслэлийн Дотоод аудитын албаны бодлого, төлөвлөгөөг оновчтой боловсруулж, тайлагнах чиглэлээр:

Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн Дотоод аудитын албаны даргатай байгуулсан 2015 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг 2016 оны 1 дүгээр сард Нийслэлийн Засаг даргын тамгын газрын ажлын хэсэгт амжилттай тайлагнаж, “БҮРЭН ХАНГАЛТТАЙ” үнэлгээ авсан. Дотоод аудитын албаны даргын 2016 оны үр дүнгийн гэрээг 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр байгуулснаар байгууллагын 2016 оны үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөөг, Нийслэлийн Дотоод аудитын хорооны 2016 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хурлаар байгууллагын 2015 оны аудитын тайланг хэлэлцүүлж, 2016 оны аудитын төлөвлөгөөг тус тус батлуулсан.

2016 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр байгууллагын дарга 4 нэгжийн даргатай, нэгжийн дарга нар албан хаагчидтай 2016 оны үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ байгуулснаар хэлтэс, албан хаагчдын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.

Байгууллагын даргын зөвлөлийн хурал, байгууллагын шуурхай зөвлөгөөнийг 14 хоног тутам, хэлтсийн хурлыг 7 хоног тутам зохион байгуулж, хэлтсүүд ажлаа 7 хоногоор төлөвлөж, өгсөн үүрэг даалгаварын биелэлтэд хяналт тавьж, даргын зөвлөлийн хуралд танилцуулан ажиллаж хэвшсэн.

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уядуулан авлигын эсрэг, сургалтын, биеийн тамир, спортын хамтлагийн, 2015 оны үйл ажиллагааг үнэлсэн ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах ажлын төлөвлөгөө, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн, Баримт бичиг нягтлан шалгах комиссын зэрэг дэд төлөвлөгөөнүүдийг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажилласан.

2. Байгууллагын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх чиглэлээр:

Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг Төрийн албаны зөвлөлийн програмд мэдээллийн бааз үүсгэн оруулсан бөгөөд нийслэл дэх төрийн албаны салбар зөвлөл, нийслэлийн Засаг даргын тамгын газрын Нутгийн захиргааны удирдлагын хэлтэст хүний нөөцтэй холбоотой шаардлагатай мэдээ, судалгааг цаг тухай бүрт нь гаргаж өгсөн.

Албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”, “Хүний нөөцийн сургалтын хөтөлбөр” дунд хугацааны төлөвлөгөөнүүдийн дагуу 2016 оны сургалтын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлж ажилласан. 2016 онд албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг нь нэмэгдүүлэх төрөл бүрийн сургалт, семинарт хамруулж, үүнтэй холбоотойгоор 4,650.0 төгрөгийн зардал гаргасан. Үүнд:

- Компанийн засаглалын сургалтад 7 албан хаагч,
- Сангийн яамны дотоод аудитын эрчимжүүлсэн сургалтад 13 албан хаагч,
- Захиргааны ерөнхий хуулийн сургалтад 22 албан хаагч,
- Нийслэлийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан "Газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийг бууруулах тухай" сургалтад 22 албан хаагч,
- Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Аудиторын сургалтад 2 албан хаагч,

- Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх сунгах сургалтад 1 албан хаагч,
- Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс зохион байгуулдаг тасралтгүй боловсролын сургалтад 1 албан хаагч,
- Монголын Хуульчдын холбооны хуульчийн үргэлжилсэн сургалтад 1 албан хаагч,
- Нийслэлийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан УИХ-аас сүүлийн үед баталсан хуулиудын сургалтад 1 албан хаагч,
- Авлигын эсрэг хуулийн сургалтад 1 албан хаагч,
- Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын сургалтад 1 албан хаагч,
- Өргөдөл гомдол хариуцсан ажилтны сургалтад 1 албан хаагч,
- Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэсээс зохион байгуулсан жилийн эцсийн аудитын сургалтад 1 албан хаагч,
- Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын сургалтад 1 албан хаагч,
- Цахим төсөв сургалтад 1 албан хаагч,
- Шилэн дансны мэдээллийн нэгдсэн цахим системийн сургалтад 1 албан хаагч,
- Албан хэрэг хөтлөлтийн шинэ програмын сургалтад 3 албан хаагч,
- Аудитын E-AUDIT програмын сургалтад 22 албан хаагч,
- Сангийн яам, ЯОУХАБ (JICA)-аас зохион байгуулсан “Улсын салбарын дотоод аудиторчуудын нэгдсэн зөвлөгөөнд 6 албан хаагч,
- Сангийн яам, Японы ЖАЙКА төсөл хамтран зохион байгуулсан “Дотоод аудитын зааварлагч” бэлтгэх сургалтад албан хаагчид оролцож, 7 албан хаагч зааварлагчийн гэрчилгээ авсан.
- Олон улсын дотоод аудитын институтын Удирдах зөвлөлийн дарга асан Филип Тарлингийн хүндэтгэлийн лекцэнд 3 албан хаагч,
- Монголын Үндэсний Дотоод Аудиторуудын Холбооны өглөөний цуврал уулзалт-сургалтад 9 албан хаагч,
- Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын VI их хуралд Санхүүгийн аудитын хэлтсийн дарга Д.Үүрийнтуяа, аудитор Д.Лувсанчимэд нар төлөөлөгчөөр сонгогдон оролцсон.

3. Албан хаагчдыг ажиллах нөхцөл бололцоогоор хангах, ажлын үр дүнг үнэлэх, ажлын идэвх санаачлагыг нэмэгдүүлэх чиглэлээр:

- 2016 оны эхний хагас жилийн байдлаар нийт 21 албан хаагчтай үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ байгуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж, хагас жилийн ажлын үзүүлэлтээр нийт албан хаагчдын 16 буюу 76 хувь нь А, 5 буюу 24 хувь нь В үнэлгээ авсан. Жилийн эцсийн байдлаар 17 албан хаагчийн үр дүнгийн гэрээг дүгнэснээс албан хаагчдын 14 буюу 82 хувь нь А, 3 буюу 18 хувь нь В үнэлгээ авч, Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн дарга Ж.Жамбалдорж, аудитор Ц.Дуламдорж, Санхүүгийн аудитын хэлтсийн шинжээч Б.Отгонцэрэн нар байгууллагын оны шилдэг ажилтнаар, Захиргаа, хуулийн хэлтсийн ахлах нягтлан бодогч Б.Сэргэлэн байгууллагын шилдэгийн шилдэг ажилтнаар шалгаруулж, 1,233.2 төгрөгөөр шагнаж урамшууллаа.
- Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг шинээр 3 албан хаагчид олгож, 3 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулсан. Төрийн жинхэнэ албан хаагчийг тангарагийг 2 албан хаагч шинээр өргөсөн. Мөн 8 албан хаагч санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч, ахлах байцаагчийн эрх авснаар албан тушаалын ангилал ахисан.

- Албан хаагчдын мэргэжлээрээ ажилласан жил, ажлын туршлага, амжилтыг нь харгалзан, болзол шаардлагыг хангасан 1 хүнийг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор, 3 хүнийг Сангийн яамны “Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнуулахаар тодорхойлон холбогдох материалыг зохих байгууллагад хүргүүлсэн боловч тайлант ондоо багтан шийдвэрлэгдээгүй.
- Байгууллагын 2015 оны үйл ажиллагааны үр дүнгээр нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудыг манлайлж, “Бүрэн хангалттай” үнэлүүлж, байгууллагаараа 5,000.0 мянган төгрөгөөр шагнуулсан.
- Байгууллагын нэг удаагийн тэтгэмж, урамшуулалд 21,700.0 мянган төгрөгийн төсөв батлуулсан. Албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, ажлын идэвх санаачлагыг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу 3 албан хаагчид байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд зааснаар нийт 1,634.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, тусламж олгосон.
- Хүүхдийн баярыг тохиолдуулан албан хаагчдын 34 хүүхдэд 1,071.0 мянган төгрөгийн бэлэг өгсөн.
- Албан хаагчдыг эрүүл мэндийн бүрэн үзлэг, шинжилгээнд хамруулж 4,988.0 мянган төгрөг зарцуулсан.
- Байгууллагын бүтэц, орон тоо өөрчлөгдсөнтэй холбоотойгоор ажлаас чөлөөлөгдсөн 3 албан хаагчид үндсэн цалингийн 3 сартай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж болох 5.3 сая олгосон.
- Байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд анхаарч, биеийн тамир, спортын хамтлагийг шинэчлэн байгуулж, ажилтан, албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдарыг чийрэгжүүлэх, хамт олонч уур амьсгалыг бүрдүүлэх, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх биеийн тамир, спортын тэмцээн, арга хэмжээнүүдийг зохион байгуулах төлөвлөгөө гарган ажиллаж байна. Албан хаагчдыг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор долоо хоног бүрийн Мягмар гарагт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын “Сүлд” спорт хорооны зааланд сагсан бөмбөг, гар бөмбөгөөр хичээллэж байна. Байгууллагын 2 жилийн ойд зориулан боулингийн тэмцээн зохион байгуулсан. Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газар, Нийслэл, дүүргийн Дотоод аудитын албадын дунд явагддаг спортын уламжлалт тэмцээнд амжилттай оролцож, манай гар бөмбөгийн холимог баг 1-р байр эзэлж, хошой аварга баг болсон. Мөн хавар, намрын бүх нийтийн их болон цас цэвэрлэгээнд идэвхтэй оролцож, бүх нийтээрээ мод тарих ажилд зориулж 105.0 мянган төгрөгийн хандив цуглуулах ажлыг зохион байгуулсан.

4. Архив, албан хэрэг хөтлөлтийг сайжруулах чиглэлээр:

- Архивын хууль тогтоомжийн дагуу нэгдүгээр улиралд 149 архивын хадгаламжийн нэгж хүлээн авч нөхөн бүрдүүлэлтийг хийснээс аудитын ажилтай холбоотой архивын нэгж 93 байсан бөгөөд Захиргаа, хуулийн хэлтсээс 48, Санхүүгийн аудитын хэлтсээс 41, Гүйцэтгэлийн аудитын хэлтсээс 40, Чанарын аудитын хэлтсээс 23 нэгж хүлээн авсан.
- Албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн хэвлэмэл хуудсыг албан хэрэгт ашиглаж, байгууллагын албан хэргийг “Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ын дагуу хэвийн хөтлөн явуулж байна. Тайлант онд тус байгууллагад 295 албан бичиг ирснээс 56 хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж, 194

албан бичгийг холбогдох байгууллага, иргэнд хүргүүлсний 64 нь хариутай албан бичиг байсан.

- 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар байгууллагын даргын 22 А тушаал, 33 Б тушаалыг албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын холбогдох заалтуудад нийцүүлэн гаргасан байна.
- 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар 29 өргөдөл ирснийг хугацаанд нь шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног 11 цаг 42 минут, индекс 0.883, үнэлгээ А байна. Энэ хугацаа нь өнгөрсөн онд 20 хоног 5 цаг 14 мин байсан бөгөөд шийдвэрлэлтийн хоногийг 1 оронтой тоонд шилжүүлэх нийслэлийн зорилтот түвшинд хүрлээ.
- Байгууллагын албан хаагчдаас 21 өргөдөл хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног 22 цаг 43 минут, индекс 0.889, үнэлгээ А байна. Энэ нь НЗД-ын хэрэгжүүлэгч агентлагуудын дунджаас 0.044, хэлтсүүдээс 0.048, албан хаагчдаас 0.03 нэгжээр илүү байна.
- Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/452 дугаар захирамжийн хэрэгжилтийн дагуу 2016 онд 21 захирамжлалын баримтанд цахим хувь үйлдэн, тусгай төрлийн архив үүсгэж, “Төрийн архивын онлайн нэгдсэн програм” <http://lavlagaa.ub.gov.mn>-д дээрх баримтуудын агуулгыг тодорхойлон шивж, цахим нөхөн бүрдүүлэлт хийсэн.

5. Дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр:

- УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр Засгийн газар, салбарын сайд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон нийт 20 тогтоол, шийдвэрийн 40 заалтыг хяналтад авч, байгууллагын жилийн төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Хяналтад авсан захирамжлалын биелэлтийг улирал бүр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.
- Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн, Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст <https://lmonitoring.gov.ub.mn/> цахим хуудсаар хугацаанд нь хүргүүлж ажилласан.

6. Байгууллагын үйл ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр:

- Байгууллагын бүтэц, орон тоо өөрчлөгдсөнтэй холбогдуулан байгууллагын дүрмийг шинэчлэн батлуулах ажлын хэсэг байгуулагдан албан хаагчдын саналыг нэгтгэн боловсруулж, НЗД-ын 2016.11.22-ны А/830 захирамжаар батлуулан байгууллагын үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.
- Байгууллагын хамт олны хурал 2 удаа, даргын зөвлөлийн хурал 14 удаа болсныг зохион байгуулж, хэлэлцэх асуудлыг батлуулан зөвлөлийн гишүүдэд танилцуулж, хурлын тэмдэглэлийг албажуулсан. Даргын зөвлөлийн хурлаас өгсөн 88 үүрэг даалгаврыг холбогдох албан тушаалтанд танилцуулж, биелэлтэд хяналтад тавьж ажиллалаа.
- Байгууллагын өдөр тутмын болон аудитын үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн актуудыг албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

- Дотоод аудитын хуулийн төсөлд багц санал боловсруулан Сангийн яам, ЯОУХАБ (JICA)-аас зохион байгуулсан “Улсын салбарын дотоод аудитуудын нэгдсэн зөвлөгөөн” дээр танилцуулсан.
- “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, энэ хуультай нийцүүлэн зарим хуульд өөрчлөлт оруулах төсөлд оруулах саналыг НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.
- Байгууллагын дэргэдэх ёс зүйн хороог шинэчлэн байгуулж, даргаар Чанарын хяналтын хэлтсийн дарга Д.Нансалмаа, гишүүдээр Захиргаа, хуулийн хэлтсийн дарга Я.Сарансүх, Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн ахлах аудитор Б.Эрдэнэсүрэн нарыг байгууллагын даргын 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/04 тушаалаар томилсон. 2016 онд иргэнээс албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаарх нэг гомдол ирснийг журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж, хариуг иргэнд хүргэсэн.
- Байгууллагын дэргэд баримт бичиг нягтлан шалгах комисс, өмч хамгаалах байнгын зөвлөл, биеийн тамир, спортын хамтлаг ажиллаж, 2016 оны ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.
- Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай ном тохимлын санг баяжуулан хуулийн эмхтгэл, нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон хэм хэмжээний эмхэтгэл, нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газраас гаргасан цуврал зэрэг 12 боть номоор номын санг баяжуулсанаар одоо нийт 95 ном, эмхэтгэл, гарын авлагыг албан хэрэгцээнд ашиглаж байна.
- Нийслэлийн авлигын эсрэг 2016 оны төлөвлөгөөтэй уялдуулан байгууллагын хэмжээнд авлигын эсрэг авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. АТГ-ын даргын тушаалаар батлагдсан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны шинэчилсэн жагсаалтын дагуу холбогдох 14 албан хаагчийн мэдүүлгийг авч, тайлан мэдээг зохих хугацаанд гаргаж өгсөн. Аудитор, шинжээчдээс аудитын ажил эхлэх бүрт ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай 103 мэдэгдэл хүлээн авч АТГ-ын програмд бүртгэсэн.
- 2016 онд байгууллагын даргын өмнөх онд гаргасан 8 тушаалд кодификаци хийн, бүртгэл хөтөлсөн.

7. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хууль журамд нийцүүлэн олон улсын стандартын дагуу хөтлөн явуулах чиглэлээр:

- Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу байгууллагын нягтлан бодох бүртгэлийг Улсын салбарын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу явуулж байна. 2016 оны байдлаар санхүүгийн 1, 2, 3 улирал, жилийн эцсийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээг 12 удаа, нэмэлт дансны мэдээг улирал бүр гаргаж, хуулийн хугацаанд зохих байгууллагад хүргүүлэн баталгаажуулж ажилласан.
- Хөдөлмөрийн тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу байгууллагын нийгмийн даатгалын тайланг сар бүр гаргаж, онлайнаар шивж цаасаар хүргүүлэн баталгаажуулсан. Байгууллагаас тайлант хугацаанд нийт 23 албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэлд 54,067.07 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварт 22,024.0 мянган төгрөг төлсөн.
- Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2016 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр баталсан “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн

хэрэгжилтийг ажил олгогч байгууллагуудад шалгах удирдамж"-ын дагуу 2014, 2015 оны байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, тайлагналтыг шалгуулж зөрчилгүй дүгнэлт авсан.

- Байгууллагын орлого, зарлагын гүйлгээг холбогдох стандартын дагуу бүртгэж, сар бүр төсвийн гүйцэтгэлийг гаргаж, жижиг мөнгөн сангийн тайланг гүйцэтгэлээр, материалын тайлан болон санхүүгийн тайланг улирал бүр гаргаж, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлэн баталгаажуулж ажилласан.
- Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу байгууллагын 2017 оны төсвийн төсөл, 2018-2019 оны төсвийн төсөөлөл, 2017 оны орлогын төлөвлөгөөний хуваарийг улирал, сараар гаргаж харьяалагдах дээд шатны байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлсэн.
- Нийслэлийн Дотоод аудитын албаны байгууллагуудад тавьсан 7,479.4 мянган төгрөгийн актыг нийслэлийн орлогод төвлөрүүлсэн.
- Байгууллагын үндсэн хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хянаж, хөрөнгийн хөдөлгөөнийг тухай бүр бүртгэж ажилласан. Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу байгууллагын 2016 оны байдлаар нийт 40 нэр төрлийн 120,737.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө тоолсон бөгөөд эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, нөөцийн ашиглалтын байдал, тооллогын дүнг нэгтгэн дүгнэлт гаргасан бөгөөд тооллогоор илэрсэн зөрчил дутагдал үгүй байна. Тооллогын дүнг нэгтгэн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, нөөцийн ашиглалтын байдалд дүгнэлт гаргасан.
- 4 жил тутам явагддаг төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг амжилттай зохион байгуулж, тайланг Чингэлтэй дүүргийн тооллогын комисст хуулийн хугацаанд хүлээлгэн өгсөн. Статистикийн тухай хуулийн дагуу 5 жил тутам болдог "Аж ахуйн нэгж, байгууллагын тооллого 2016"-д Нийслэлийн Дотоод аудитын албыг хуулийн хугацаанд нь тоолуулсан.
- Нийслэлийн Өмчийн харилцааны газраас байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн 2015 оны үйл ажиллагааг дүгнэж, 100% үнэлгээ өгсөн.
- Нийслэлийн Аудитын газраар байгууллагын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж, зөрчилгүй санал дүгнэлт, мөн тус газрын завсрын аудит буюу үзлэг тооллого, 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн явцын аудит, шилэн дансны аудитад шалгуулж зөрчилгүй дүгнэлттэй ажилласан.

8. Байгууллагын ил тод нээлттэй байдлыг хангах

- Холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудсанд шилэн дансны мэдээллийн цэс үүсгэж, шилэн дансны нэгдсэн системд 2016 оны төсөв, 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, 2016 оны 1-12 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, энэ оны 4 удаагийн санхүүгийн тайлан, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, аудитын дүгнэлт, аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тухайн байгууллагын жилийн төсөв, дараа жилийн төсвийн төсөл, хагас бүтэн жилийн гүйцэтгэлийн KPI, төсвийн тодотгол болон бусад холбогдох мэдээллийг нийтэлсэн.
- Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор байгууллагын нэр, лого, эрхэм зорилго, стратегийн зорилт, бүтэц зохион байгуулалт, дагаж мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, холбоо барих хаяг, хүний нөөцийн бодлогын ил тод байдлын 12 мэдээлэл, Нийслэлийн Дотоод аудитын албаны 2015 оны үйл ажиллагааны тайлан, тогтоол, шийдвэрийн 2015 оны гүйцэтгэлийн мэдээ, мэдээллийн ил, тод байдал, 2015 оны өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн

дэлгэрэнгүй тайлан, 2015 оны авилгын эсрэг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, байгууллагын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2016 оны ажлын төлөвлөгөө, 2016 оны сургалтын төлөвлөгөө, 2016 оны авилгын эсрэг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тэдгээрийн биелэлт, цаг үеийн мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудсанд нийтэлсэн.

- Хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг хангах зорилгоор батлагдсан 22 орон тоонд ажиллаж буй албан хаагчдын мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, тухай бүр шинэчилсэн. Мөн төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтны ёс зүйн дүрэм, ажлын байрны тодорхойлолт, мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийг байгууллагын цахим хуудсанд нийтэлсэн.

9. Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн технологийн хэрэглээг нэмэгдүүлэх

- Интернэтийн үйлчилгээг Нийслэлийн мэдээлэл технологийн газар, Комтел ХХК-аас 2Мб-ын урсгалыг авч байна. Интернэтийн урсгалын хурдыг <http://192.168.205.1/graphs/iface/Audit/> системээр хэмжин ажилласан.
- Дотоод сүлжээний техник хангамж болох 6 свич, сүлжээний кабел зэргийн хэвийн ажиллагааг хангаж ажилласан. Байгууллагын 22 компьютер, бусад техник хэрэгсэл дотоод, гадаад сүлжээнд бүрэн хэмжээгээр холбогдон ажиллаж байна. Компьютерийн программ хангамж болон техник хангамж, принтер, факс, сканнерийн засварыг цаг тухайд нь хийж хэвийн ажиллагааг хангаж ажилласан.
- Байгууллагын бүх буюу 22 компьютерт албан ёсны эрхтэй хортой кодны эсрэг програм хангамж суулгаж, Галт хана (firewall) системээр сүлжээний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Smartcity, э-оффис, цахим архив, захирамжлалын баримт бичгийн биелэлтийн L monitoring, шилэн данс зэрэг төрийн ажил үйлчилгээг цахимжуулах технологийн дэвшилтэт шинэ програмуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Өргөдөл, гомдлын smartcity, албан хэрэг хөтлөлтийн Edoc системийн шинэчлэлтэй холбоотойгоор байгууллагын бүх компьютерт програмыг суулгаж холбогдох тохиргоог хийсэн.
- Дотоод аудитын төлөвлөгөөт болон захиалгат аудитын ажлыг үүсгэх, явцыг хянах, аудитор, шинжээчдийн ажлыг хөнгөвчлөх, хянах, дүгнэх, тайлагнахад хялбар болгохын тулд үйл ажиллагаандаа тохирсон програм хангамжийг захиалгаар хийлгэн хэрэглээнд нэвтрүүлж байна.
- Smartcity, цахим архив, захирамжлалын баримт бичиг, шилэн данс, албан хэрэг хөтлөлтийн Edoc зэрэг төрийн ажил үйлчилгээг цахимжуулах технологийн дэвшилтэт шинэ програмуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэж байна.

\

ХОЁР. 2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АУДИТЫН ТАЛААР

Нийслэлийн Дотоод аудитын алба нь 2016 онд нийслэлийн Засаг даргын хамрах хүрээний нийт 19 байгууллагад гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитыг гүйцэтгэхээр төлөвлөснөөс 32 байгууллагад аудитын ажлыг гүйцэтгэсэн.

Аудитын төрөл	Зөвлөмжийн тоо	Төлөвлөсөн аудит	Гүйцэтгэсэн аудит
Санхүүгийн аудит	54	6	11
Гүйцэтгэлийн аудит	209	13	21
Дүн	263	19	32

Захиалгат аудитыг дараах 11 байгууллагад гүйцэтгэсэн. Үүнд:

1. Нийслэлийн ОНХС-ийн 2015 оны гүйцэтгэлд аудит хийх
2. Нийслэлд Улс, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд хийх аудит
3. 2013-2015 онуудад хийгдэж ашиглалтад орсон зарим авто замуудын гэрэлтүүлгийн ажлын гүйцэтгэл болон ашиглалтын байдалд хийх аудит.
4. Улс болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудын бэлтгэл ажлын хүрээнд хийх шалгалт
5. ХУД-ийн 18 дугаар сургууль, Нийслэлийн Боловсролын газарт хяналт шалгалт
6. Нийслэлийн Боловсролын газар, Нэгдүгээр сургуульд хяналт шалгалт
7. Нийслэлийн Соёл, урлагийн газар;
8. Хүүхдийн урлан бүтээх төв;
9. Өмчийн харилцааны газрын Улсын төсвийн орлого;
10. Хөгжлийн банкнаас олгосон санхүүжилтийн дагуу Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний явц, үр дүнд хийх хяналт, шалгалт;
11. Авто худалдааны цогцолбор ОНӨААТҮГ.

2016 онд хэрэгжүүлсэн дээрх 32 аудитын ажлын хүрээнд 263 зөвлөмж хүргүүлж, нийт 11,190.3 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 10,356.2 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх, 817.1 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулах, 17.0 сая төгрөгийн зөрчлийг акт тогтоож, төсөвт буцаан төвлөрүүлэхээр холбогдох байгууллагуудад дүгнэлт, зөвлөмж өгч ажиллаа.

Аудитын төрөл	Зөрчлийн дүн	Өгсөн зөвлөмж		
		Төсөвт буцаан төвлөрүүлэх	Данс бүртгэлд тусгах, залруулах	Давтан гаргахгүй байх
Санхүүгийн аудит	7,653.2	4.5	10.9	7,637.8
Гүйцэтгэлийн аудит	3,537.1	12.5	806.2	2,718.4
Дүн	11,190.3	17.0	817.1	10,356.2

2.1. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЛААР:

Гүйцэтгэлийн аудитын багт хэлтсийн дарга Ж.Жамбалдорж, ахлах шинжээч Н.Наранчимэг, ахлах аудитор Б.Эрдэнэсүрэн, аудитор Ц.Дуламдорж, шинжээч Б.Мягмарзаяа, Ц.Болдбаатар, О.Баярмагнай нарын бүрэлдэхүүнтэйгээр 1587 хүн/өдөр ажиллаж, тайлант хугацаанд /шаардлагатай үед бусад хэлтсүүдтэй хамтран/ өөрийн чиг үүргийн дагуу дараах захиалгат /сэдвийн/ аудитын ажлыг гүйцэтгэсэн.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 3,537.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж, нийт 209 зөвлөмж өгснөөс 806.2 сая төгрөгийн зөрчлийг тайланд залруулах, 2,518.3 сая төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, 13.0 сая төгрөгийн зөрчлийг төсөвт буцаан төвлөрүүлэх зөвлөмжийг хүргүүлсэн.

А. Захиалгат аудитын ажил:

1. Нийслэлийн Засаг дарга, Дотоод аудитын хорооны дарга Э.Бат-Үүлийн баталсан удирдамжаар нийслэлд улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2010-2015 онуудад хийсэн болон 2016 онд хийхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн байдалд 04, 05 дугаар саруудад захиалгат аудит хийж, дүнг нийслэлийн Засаг даргын Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан орлогч Н.Батаад танилцуулан, аудитын зөвлөмжийг нийслэлийн ЗДТГ-ын Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн. Хэлтсийн дарга Ж.Жамбалдорж болон ахлах шинжээч Н.Наранчимэг нар улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийх ажлуудын бэлтгэл ажлын байдалд хийсэн шалгалтын ажлын хэсэгтэй хамтран ажиллаж холбогдох материалуудыг солилцсон.

2. Нийслэлийн Боловсролын газар, Хан-Уул дүүргийн Ерөнхий боловсролын 18 дугаар дунд сургуулийн дотоод үйл ажиллагаа болон санхүүгийн байдалд аудит хийж, дүнг нийслэлийн Засаг даргын орлогч Ц.Энхцэнгэлд танилцуулан, аудитын зөвлөмжийг нийслэлийн Боловсролын газар, 18 дугаар сургуулийн захиргаанд хүргүүлж, хариу арга хэмжээний төлөвлөгөөг хүлээн авч, төлөвлөлгөөний хэрэгжилтийг хянан ажиллаж байна.

3. Нийслэлийн Авто замын газрын захиалгаар 2013-2015 онуудад ашиглалтад оруулсан зарим авто замуудын гэрэлтүүлгийн ажлын гүйцэтгэл болон ашиглалтын байдалд 06 дугаар сард захиалгат аудитыг хийж, дүнг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Б.Бадралд танилцуулан, аудитын зөвлөмжийг Захирагчийн ажлын алба, нийслэлийн Авто замын газарт хүргүүлсэн.

4. Сүхбаатар дүүргийн Ерөнхий боловсролын 1 дүгээр дунд сургуулийн зарим үйл ажиллагаанд захиалгат аудит хийж, дүнг нийслэлийн Засаг даргын зөвлөх Л.Ганхөлөгт танилцуулсан. Аудитын зөвлөмжийг нийслэлийн Боловсролын газар болон 1 дүгээр сургуулийн захиргаанд хүргүүлсэн.

5. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг үндэслэн нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 2015 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийсэн.

6. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт Төсвийн тухай хуулийн 29.4 “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” заалтын хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийсэн.

Доор дурьдсан хяналт шалгалт болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд албан хаагчдаас орж ажилласан байна. Үүнд:

1. Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 дахь заалтын дагуу Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний биелэлтийн явцад 9 дүүргийн ЗДТГ-ыг хамруулан аудит хийж 2015 оны ажилд үнэлгээ өгсөн.

2. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2015 оны ажил дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд албаны дарга болон хэлтсийн дарга нар орж ажилласан ба ажлын хэсгүүдийн холбогдох материалуудыг аудитын баримт болгон архивын хадгаламжийн нэгж болгон бүрдүүлсэн.

3. Хэлтсийн дарга болон ахлах шинжээч Н.Наранчимэг нар улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудын бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн шалгалтын ажлын хэсэгтэй хамтран ажиллаж холбогдох материалуудыг солилцсон.

4. Хэлтсийн дарга Ж.Жамбалдорж НЗД-ын орлогч Д.Энхтөрийн ахалсан ажлын хэсэгт ажиллан жижиг дунд үйлдвэрлэлийн төв, Гэрлэх ёслолын ордон зэрэг 6 байгууллагын ажилтай танилцаж илтгэх хуудас бичсэн.

5. Нийслэлийн хөдөлмөрийн газрын бичил зээлийн санд хийсэн үзлэг шалгалтын ажлын хэсэгт холбогдох материалуудыг тус хэлтсээс гарган өгсөн ба шалгалтын нэгдсэн илтгэх хуудсыг аудитын материал болгон авсан.

6. Хөгжлийн банкнаас олгосон санхүүжүүлтийн дагуу НЗД-ын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжсэн төсөл арга, хэмжээний явц үр дүнд нарийвчилсан шалгалт хийж шалгалттай холбогдох материалыг НЗДТГ-т хүргүүлсэн.

7. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын захиралтай нийслэлийн Өмчийн харилцааны газраас байгуулсан 2015 оны контрактыг дүгнэх ажлын хэсэгт албаны дарга ажилласантай холбогдуулж 2015 онд тус хэлтсээс 30 байгууллагын статус, санхүүжилт, бүтэц, зохион байгуулалт, ажлын байрны тодорхойлолтод хийсэн гүйцэтгэлийн аудитын материал болон өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг контракт дүгнэхтэй хамтатган шалгасан.

Б.Төлөвлөгөөт гүйцэтгэлийн аудит:

Аудитын жилийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн аудитыг нийслэлийн харьяа доорх байгууллагын 2015 оны үйл ажиллагаанд хийсэн. Үүнд:

1. Нийслэлийн Өргөө амаржих газар
2. Нийслэлийн Хүрээ амаржих газар
3. Нийслэлийн Амгалан амаржих газар
4. Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, хуваарлалт, зарцуулалт
5. Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв
6. Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв
7. Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв
8. Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв
9. Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв
10. Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг
11. Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв
12. Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг
13. Нийслэлийн Түргэн тусламжийн төв
14. Нийслэлийн Эрүүл мэндийн газар

Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтын 3.10.6-д нийслэлийн Дотоод аудитын алба нь жилийн туршид "Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудад эрсдэлд суурилсан гүйцэтгэлийн аудит хийнэ" гэж тусгагдсан дагуу тайлант онд

ОНӨТҮГ, ОНӨААТҮГ-уудаас эрсдэл бүхий 8 байгууллагад аудит хийхээр төлөвлөн батлуулсан Үүнээс доорх байгууллагуудад аудит хийгдсэн:

1. "Улаанбаатар лифт" ОНӨТҮГ;
2. "Нийслэлийн Орон сууцны корпараци" ОНӨААТҮГ,
3. "Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв" ОНӨААТҮГ-т аудит хийсэн.

Нийслэлийн хэмжээнд архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг 2015 онд явагдсан учир энэ онд хийсэн аудитаар байгууллагуудын дотоод ажил сайжирсан, тус албаны санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжүүд хэрэгжиж байгаа боловч санхүү, гүйцэтгэл, сэдвийн болон захиалгат аудит хийж байгаагүй байгууллагуудаас дараах нийтлэг зөрчлүүд илэрч байна. Үүнд:

- Зарим ОНӨҮГ, ОНӨТҮГ, ОНӨААТҮГ-ын статус, санхүүжилтийн хэлбэр буруу, улсын бүртгэлийн гэрчилгээнд хуульд заагаагүй НӨҮГ гэсэн нэршлээр бичсэн;
- Байгууллагын даргын зөвлөлийн хурал тогтмолжоогүй;
- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд нийслэлийн ЗДТГ-т ирүүлдэг мэдээ, мэдээллийг хугацаа хоцроодог болон ирүүлэхгүй байх;
- Байгууллагын стратеги болон бизнес төлөвлөгөөг батлуулж ажилладаггүй;
- Дотоод хяналтын систем сул ажилладгаас зөрчил, дутагдлыг илрүүлэн арилгадаггүй;
- Санхүүгийн тайланд авлагыг тухай бүр тусган барагдуулдаггүй;
- Орлогын төлөвлөгөө нь хоцрогдолтой, зардлын төлөвлөгөөг хэтрүүлэн контрактаар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлдэггүй;
- Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлтийг тухай бүр хийгээгүй;
- Жолоочийн замын хуудасгүйгээр шатахууны зардал гаргадаг;
- Анхан шатны баримтгүй ажил, үйлчилгээг бүртгэл, тайланд тусгадаг;
- Тендерийн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлийг дутуу хөтөлдөг, гаргасан шийдвэр тодорхойгүй зэрэг болно.

"Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтад ашиг сонирхлын зөрчлөөс урдчилан сэргийлэх тухай журам"-ын холбогдох заалтын хүрээнд аудит хийх болон хийж байгаа байгууллагуудын удирдлага, албан хаагчидтай 58 удаа уулзалт хийж, тэмдэглэлийг тухай бүр хөтөлж /Ажлын баримт 1002-ын А,Б/ албажуулсан.

Аудит хийж байгаа байгууллагуудын удирдлагаас авах асуулга, /Ажлын баримт 1003/ албан хаагчдаас авах дотоод хяналтын асуулга /Ажлын баримт 1004/-ыг 80 гаруй албан хаагчаас авч дүнг нэгтгэн аудитын тайланд тусгаж ажиллалаа.

2.2. САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЛААР:

Санхүүгийн аудитын багт 2016 онд хэлтсийн дарга Д.Үүрийнтуяа, ахлах аудитор Д.Лувсанчимэд, С.Цолмон, аудитор Ч.Гүрбазар, Б.Уранбилэг, шинжээч Б.Отгонцэрэн, Б.Баярмаа нарын бүрэлдэхүүнтэйгээр тайлант хугацаанд 1546 хүн/өдөр /давхардсан тоогоор/ ажиллаж, тайлант хугацаанд байгууллагын дунд хугацааны төлөвлөгөө, аудитын жилийн төлөвлөгөөнд үндэслэн аудитын хамрах хүрээний байгууллагуудын 2015 оны санхүүгийн тайланд аудит хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж хүргүүлэх, 2015 оны санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийг хянах зорилгоор аудитыг хийж гүйцэтгэлээ.

Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Гурав. Ажилтай, орлоготой Улаанбаатар 3.10. "Нийслэлийн санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх чиглэлээр:" зорилтын хүрээнд

эрсдэлд тодорхойлогдсон хамрах хүрээний байгууллагад санхүүгийн төлөвлөгөөт аудитыг хийж гүйцэтгэлээ.

Төсвийн тухай хуулийн 69.3. *"Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна."* заалт, Засгийн газрын 2016 оны 483 дүгээр тогтоол, Нийслэлийн Дотоод аудитын хорооны дарга Э.Бат-Үүлийн 01 тоот тогтоолоор баталсан тус албаны 2016 оны аудитын жилийн төлөвлөгөөний дагуу санхүүгийн болон сэдвийн нийт 11 аудитыг гүйцэтгэсэн. Аудитаар нийт 7653.2 сая төгрөгийн зөрчил илэрч, 54 зөвлөмж өгснөөс 10.9 сая төгрөгийн зөрчлийг тайланд залруулах, 4.5 сая төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоож, 7637.8 сая төгрөгийн зөрчлийг цаашид дахин давтан гаргахгүй байх дүгнэлт, зөвлөмж өгч ажилласан. Үүнд:

2016 оны аудитын жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 17 аудитаас 6 аудитын удирдамжийг төлөвлөгөөний дагуу мөн 3 захиалгат аудитын удирдамжийг боловсруулж, Дотоод аудитын хорооны даргаар батлууллаа. Календарчилсан төлөвлөгөөний дагуу 6 аудит хийхээр төлөвлөснөөс аудитыг төлөвлөгөөт хугацаанд дуусгаж, аудитын дүгнэлт зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. Үүнд:

А. Төлөвлөгөөт санхүүгийн аудит: 2016 оны аудитын жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 7 аудитын удирдамжийг боловсруулж, Дотоод аудитын хорооны даргаар батлууллаа. Үүнд:

1. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
2. Нийслэлийн Өмчийн харилцааны газар
3. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
4. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ
5. Усан спорт сургалтын төв ОНӨААТҮГ
6. Шилэн дансны тухай хуулийн 2015 оны хэрэгжилтэнд хийх үзлэг шалгалт
7. Шилэн дансны сар бүрийн хяналт

Санхүүгийн аудитаар 2015, 2016 оны санхүүгийн тайлан нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/ болон холбогдох хууль тогтоомжийн заалтууд, заавар журмын дагуу бэлтгэгдэж буй эсэхэд аудит хийж, тайлант хугацаанд илэрсэн зөрчил, дутагдлыг холбогдох ажилтнуудад танилцуулан, заавар зөвлөгөө өгч ажиллав.

Аудитын зорилгоо *"Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам бусад холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, заавар журам, стандартын хэрэгжилтэнд хяналт тавих, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтын хэрэгжилт, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино."* гэж тодорхойлсон.

Аудитын цар хүрээний хувьд 2015, 2016 оны санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн журналууд, анхан шатны баримтаас түүвэрлэн, аудитын горимыг

хэрэгжүүлсэн болно. Явцын аудит хийх зорилго, зорилттой холбогдуулан дараах хууль, эрх зүйн актыг шалгуур болголоо. Үүнд:

1. Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөх санхүү болон нягтлан бодох бүртгэлтэй холбоотой хууль, заавар журам, тогтоол, шийдвэрүүд /Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хуулиуд, Засгийн Газрын 2015 оны 483 дугаар тогтоол, Сангийн сайдын баталсан журам, заавар, Нийслэлийн ИТХ-ын тогтоолууд, Засаг даргын захирамжууд ... гм/
2. СТОУС, УСНББОУС, Улсын салбарын дотоод аудитын гарын авлага, Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ, Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартууд

Аудитыг гүйцэтгэхдээ албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, биет тест хэрэгжүүлэх зэрэг нотлох баримт цуглуулан танилцаж судлах, нөхцөл байдлын шинжилгээ хийн шалгалтыг гүйцэтгэсэн.

Аудит хийгдсэн байгууллагын удирдлагад Санхүүгийн аудитын тайланг танилцуулан “Илэрсэн асуудлын жагсаалт Ажлын баримт 3003, Удирдлагын харуу арга хэмжээний төлөвлөгөө ажлын баримт 3004”-ыг албан бичгийн хамт хүргүүлсэн. Санхүүгийн аудитаар иж бүрэн байх, эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт, бодитоор оршин байх, тайлан ба тодруулга зэрэг санхүүгийн аудитын горимуудыг хэрэгжүүлж ажиллалаа.

Санхүүгийн аудитыг 9 зорилтын хүрээнд 5 байгууллагад хийсэн бөгөөд зорилт бүрээр илэрсэн зөрчлийг нэг бүрчлэн доор харууллаа.

1. *Дотоод хяналтын талаар*

ӨХБЗ, Дотоод хяналтын үйл ажиллагаа нь тогтмолжоогүй, байнгын бус ажиллагаатай

2. *Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар*

Шилэн дансны цахим хуудсанд 2016 оны 3 дугаар улирлын байдлаарх мэдээллийг бүрэн байршуулаагүй

3. *Санхүүгийн тайлагналын талаар:*

- Тайлант оны эцэст “тэг үлдэгдэлтэй” байх ёстой дансны 49.6 сая төгрөгийн үлдэгдлийг тухайн онд нь багтаан төсөвт төвлөрүүлээгүй.
- Орлогын нэг төгрөгт ногдох 0.97 төгрөгийн зардалтай ажиллахаар төлөвлөсөнөөс 1.39 төгрөгийн зардал гаргаж 0.42 төгрөгөөр хэтрүүлэн ажилласан.
- УССТ-ийн ашигт ажиллагааг өмнөх онтой харьцуулан авч үзвэл 0.03, хөрөнгийн ашигт ажиллагаа 0.01, эздийн өмчийн ашигт ажиллагаа 0.01-ээр тус тус буурсан.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба горимд холбогдох хууль, дүрэм, журам, стандартын зарим өөрчлөлтийг тусгаагүй.

2. *Эргэлтийн хөрөнгийн талаар:*

Эргэлтийн хөрөнгөтэй холбоотой 4 байгууллагын 75.4 сая төгрөг зөрчил илэрсэн. Үүнд:

- 2007 оноос өмнө үүссэн нийт 15.4 сая төгрөгийн түрээсийн авлага өнөөдрийг хүртэл барагдаагүй;
- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 3.5 сая төгрөгийг зарцуулсан;
- 2 жилээс дээш насжилттай авлага 1.2 сая төгрөг.

- Нийт 52.9 сая төгрөгийн 2009 оноос өмнө үүссэн авлагыг барагдуулаагүй, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлээгүй нь ирээдүйд хариуцах эзэн нь тодорхой бус, шүүхийн зарга маргаан үүсэх эрсдэлтэй;
- Нийт 309 ширхэг Усан спорт сургалтын төвийн бассейнд үйлчлүүлэх эрхийн үнэмлэх бараа материалын дансанд бүртгэлд тусгаагүй нь бодитой оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- Бараа материал дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 5 нэр төрлийн 1.5 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн.

3.Эргэлтийн бус хөрөнгийн талаар:

Эргэлтийн бус хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 3 байгууллагын 342.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Үндсэн хөрөнгийг ангиллын дагуу бүртгээгүй 6.5 сая төгрөг
- НӨХГ-ийн зөвшөөрөлгүй 138.2 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн.
- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 111.8 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан.
- Биетээр хүлээн аваагүй нийт 85.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авч данс бүртгэлд тусгасан.
- Нийт 0.5 сая төгрөгийн өртөг бүхий 2 нэр төрлийн үндсэн хөрөнгийг дансны ангилал зөрүүтэй бүртгэсэн;
- Үндсэн хөрөнгө дансанд тухайн дансны шалгуурыг хангахгүй 0.2 сая төгрөгийн программын лицензийг бүртгэж элэгдэл байгуулсан байна.

4. Хөрөнгийн эх үүсвэрийн талаар:

Нийт 3 байгууллагын 496.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Санхүүгийн тайланд 4.9 сая төгрөгийн өр төлбөрийг алдаатай илэрхийлсэн.
- Нийт 21.8 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж, акт үйлдээгүй.
- Урт хугацаат зээлийн хүүгийн өглөгийг нийт 406.3 сая төгрөгөөр бууруулж, урт хугацаат зээлийн өглөгийн дүнд тухайн дүнгээр нэмэгдүүлсэн.
- Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг нийгмийн даатгалын тайлан, санхүүгийн байдлын тайланд 0.058 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан;
- Нийслэлийн татварын газрын хяналт шалгалтаар 2009-2013 онд үүссэн 63.2 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй.

5. Орлогын талаар:

Орлогын бүртгэлтэй холбоотой 3 байгууллагын 15.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Тайлант хугацаанд “Улаанбаатар хотын даатгал” ХХК-аас авах ёстой ногдол ашгийн 4.3 сая төгрөгийн төсвийн орлогыг бүрдүүлээгүй байна;
- Түрээсийн төлбөрийн доод үнийг нийт 1.0 сая төгрөгөөр бага тогтоосон;
- Халаалтын тооцоог 1 хоногоор дутуу тооцон оршин суугчдаас 9.7 сая төгрөгийг илүү ногдуулсан байна.
- Тайлант хугацаанд орлогын төлөвлөгөө биелээгүй нь “УССТ” ОНӨААТҮГ-ын захиралтай байгуулсан контрактын Гурав. Үйлдвэрийн газрын захирлын эрх, үүрэг. 3. “... контрактын хавсралтанд тусгасан үзүүлэлтүүдийг биелүүлэн үйлдвэрийн газрын ашиг орлогыг нэмэгдүүлэх үндсэн үүрэг хүлээнэ...” заалт хэрэгжихгүйд хүрэх эрсдэлтэй.
- НӨХГ-т түрээсийн төлбөрийн 60 хувь буюу 0.4 сая төгрөгийг тушаагаагүй.

6.Зардлын талаар:

Зардлын тайлагналтай холбоотой 5 байгууллагын 6673.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Магистрын ангийн сургалтын төлбөрт 4.1 мянган төгрөгийн тэтгэлэг олгосон;
- Дүүргүүдийн өмч газрын харилцааны албадад олгосон 58.6 сая төгрөгийн бэлэн мөнгөний зарлагын ажил гүйлгээ бүрийг цаг хугацааны дарааллаар мөнгөн хөрөнгийн журналд бүртгээгүй, нийт дүнгээр зардалд тайлагнасан;
- Спидометрийн заалтгүйгээр нийт 2.8 сая төгрөг, шатахууны норм нормативыг мөрдөөгүй 7.7 сая төгрөг;
- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 20.7 сая төгрөг зарцуулсан;
- Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй төрийн захиргааны 7 албан хаагчид мэргэшсэн инженерийн нэмэгдлийг 15 хувиар буюу нийт 4.5 сая төгрөг олгосон байна;
- Ээлжийн амралт болон цалинг давхардуулан 48.7 сая төгрөгийн цалин хөлс олгосон;
- Тооцооны дансаар дамжуулаагүй 21.2 сая төгрөг, мөнгөн урьдчилгааны тайлан бэлтгээгүй 11.7 сая төгрөг;
- Төсвийн урамшууллыг зарцуулах журмыг зөрчин ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 30.3 сая төгрөг олгосон;
- Төрийн үйлчилгээний албан хаагчдад 7.1 сая төгрөгийн үр дүнгийн гэрээний урамшил олгосон.
- ХХОАТ-ийн суутгаагүй 0.4 сая төгрөг, үр ашиггүй зардал гаргасан 0.2 сая төгрөг.
- ТБОНӨХБАҮХАТХ-ийн холбогдох заалтыг мөрдөөгүй 1105.3 сая төгрөг.
- Төлөвлөсөн зорилтод түвшиний төлөвлөгөөг хэтрүүлэн 5347.9 сая төгрөгийг зарцуулсан.
- Зардлын 0.96 сая төгрөгийн гүйлгээг журналд эдийн засгийн ангиллын дагуу тайлагнаагүй;
- нийт 0.2 сая төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу зарцуулсан;
- Нийт 1.3 сая төгрөгийн НӨАТ-тай худалдан авалтыг НӨАТ-ын тайланд тайлагнаагүй.

Зөрчлийн товчоо

/сая.төгрөгөөр/

№	Байгууллага	Санхүүгийн тайлагналын талаар	Эргэлтийн хөрөнгийн талаар	Эргэлтийн бус хөрөнгийн талаар	Хөрөнгийн эх үүсвэрийн талаар	Орлогын талаар	Зардлын талаар	Нийт
1	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ		1.2	6.5			59.9	67.6
2	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар		0.2				51.3	51.5
3	Нийслэлийн Өмчийн харилцааны газар	49.6	18.7		4.9	5.3	62.4	140.9
4	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар			335.7	428.1	9.7	6497.6	7271.1
5	Усан спорт сургалтын төв		55.3	0.6	63.3	0.4	2.5	122.1
	Дүн	49.6	75.4	342.8	496.3	15.4	6673.7	7653.2

Дээрх зөрчилтэй холбоотой дараахь зөвлөмжүүдийг өгсөн бөгөөд үүнийг хүснэгтээр харуулбал:

Санхүүгийн аудитын зөвлөмж

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Тайланд залруулах	Давтан гаргахгүй байх	Суутган төсөвт төвлөрүүлэх	Нийт дүн
1	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ	5.8	61.8		67,6
2	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар	0.2	46.8	4.5	51,5
3	Нийслэлийн Өмчийн харилцааны газар	4.9	136.0		140.9
4	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар	0.0	7271.1		7271.1
5	Усан спорт сургалтын төв	0.0	122.1		122.1
Нийт		10.9	7637.8	4.5	7653.2

Өргөдлийн дагуу хийсэн хяналт шалгалт, аудит

Тайлант хугацаанд тус хэлтсийн ажилтнууд өргөдлийн дагуу 6 хяналт шалгалт хийсэн. Үүнд:

1. Нийслэлийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч даргын баталсан удирдамжаар Нийслэлийн Соёл урлагын газрын зарим үйл ажиллагаанд шалгалт хийсэн.
2. Сангийн сайдын 2016 оны 02 дугаар сарын 29-ны өдрийн “Барилга, хот байгуулалтын яам, болон түүний харъяа байгууллагуудын үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын нэгдсэн удирдамж”-ийн 5.2.4.-ийн дагуу “Дүүргүүдийн газрын албадад хийгдсэн шалгалтын дүнг НДАА-ны ажлын хэсэг нэгтгэн СЯ-нд ирүүлэх”, мөн СЯ-ны 2016 оны “Шалгалт хийлгэх тухай” 12-2/1823 дугаар албан тоотуудыг үндэслэн НДАА-ны санхүүгийн аудитын хэлтэс нь нийслэл, дүүргүүдийн газрын албадад хийгдсэн шалгалтын дүнг нэгтгэн 2016 оны 04 дүгээр сарын 12-ны 55 дугаар албан бичгээр СЯ-нд хүргүүлсэн.
3. Нийслэлийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Хүүхдийн урлан бүтээх төвийн зарим үйл ажиллагаанд шалгалт хийн илтгэх хуудас холбогдох баримтыг Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.
4. Нийслэлийн Засаг даргын баталсан удирдамжаар ХУД-ын 18 дугаар сургуулийн зарим үйл ажиллагаанд иргэнээс ирсэн өргөдлийн дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэсэн.
5. Нийслэлийн Засаг дарга С.Батболдын 2016 оны А/743 дугаар захирамжаар баталсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2013-2016 онд нийслэлийн хэмжээнд Хөгжлийн банкнаас олгосон санхүүжилтийн дагуу Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний явц, үр дүнд 2016 оны 11 сарын 21-ний өдрөөс 2016 оны 11 дүгээр сарын сарын 23-ны өдрүүдэд хугацаанд шалгалтыг НДАА-ны дарга Б.Жавзан, гүйцэтгэлийн хэлтсийн дарга Ж.Жамбалдорж, аудитор Ц.Дуламдорж, байцаагч Ч.Гүрбазар, аудитор

- Б.Уранбилэг нарын хамт хийж гүйцэтгэн НЗДТГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хийсэн ажлын тайланг хүргүүлсэн.
6. НЗД-ийн албан бичгийн дагуу Авто худалдааны цогцолбор ОНӨААТҮГ-т аудит хийсэн.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн сар бүрийн хяналт

Нийслэлийн харьяа төсөвт 44, ОНӨААТҮГ-23 нийт 66 байгууллагын Шилэн дансны тухай хууль, журмын 2016 оны 1-11 сарын хэрэгжилтэнд сар бүр хяналт тавьж ажилласан.

НАГ-аас нийслэлийн харьяа байгууллагуудын шилэн дансны хэрэгжилтэд аудит хийж “Албан шаардлага” ирүүлснийг байгууллага бүрт албан бичгээр мэдэгдэн зөрчлийг залруулуулахаар хугацаатай үүрэг өгч биелэлтийг НАГ-т албан бичгээр хүргүүлсэн.

ЗГХЭГ-аас 2016 оны 12 сарын 05-ны өдөр ирүүлсэн “Аудитын зөвлөмжийн биелэлтийг ирүүлэх тухай” албан бичгийн дагуу 2015 оны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээ, биелэлтийг гарган 2016 оны 12 сарын 13-ны өдөр цахимаар явуулсан.

Санхүүгий аудитын хэлтэс нь 2016 оны I, II, III дугаар улиралд нийт 66 байгууллагын шилэн дансны мэдээг нэгтгэн Сангийн яаманд улирал бүр хүргүүлсэн.

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮЗЛЭГ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

Санхүүгийн аудитын хэлтэс нь 2016 онд Шилэн дансны үзлэг шалгалтыг 2015 оны жилийн эцэс болон 2016 оны эхний хагас жилээр тасалбар болгон шалгасан.

1. 2015 оны жилийн эцсийн үзлэг шалгалт

Шилэн дансны тухай хуулийн 8.2. “Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.”, нийслэлийн Засаг даргын 2015 оны А/01 дүгээр захирамжийн 2. “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг нийслэл, дүүргийн хэмжээнд зохион байгуулахад дараах хяналт шалгалтыг тогтмол хэрэгжүүлж, ажиллахыг нийслэл, дүүргийн Дотоод аудитын албанд үүрэг болгосугай.” заалтуудын дагуу Шилэн дансны тухай хууль, журмын 2015 оны хэрэгжилтийн үзлэг шалгалтыг 2016 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөр тасалбар болгон хийж дүнг нэгтгэн тайлагнасан.

Нийслэлийн харьяа 66 /төсөвт-44, ОНӨААТҮГ-23/ байгууллагын удирдлагуудад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийх аудитын удирдамж, бүрдүүлэх материалын жагсаалтыг албан бичгийн хамт хүргүүлсэн. Нийслэлийн харьяа байгууллагууд дээр биечлэн очиж шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулсан мэдээллийг баримттай тулган аудитыг гүйцэтгэсэн. Аудитаар Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийг хянаж, илэрсэн зөрчлийг холбогдох ажилтнуудад танилцуулан, залруулуулж цаашид анхаарах зүйлийн талаар зөвлөгөө өгч ажиллаа.

Шилэн дансны тухай хууль, журмын 2015 оны хэрэгжилтийн үзлэг шалгалтаар нийт 70 тэрбум 102.3 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж тухай бүр залруулуулсан. Үүнд:

- Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан 1 байгууллагын 5.7 сая төгрөгийн тайланг;
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 10 байгууллагын нийт 7238.7 сая төгрөгийн 136 гүйлгээг;
- Нийт 5 байгууллагын 19268.5 сая төгрөгийн 180 тендерийг;
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг 7 байгууллагын 43589.4 сая төгрөгийн гүйлгээг;
- Дараа жилийн төсвийн төслийг 2 байгууллага;
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг 1 байгууллага;
- Санхүүгийн тайланг 4 байгууллага;
- 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 3 байгууллага;
- Байгууллагын өмч хөрөнгөтэй холбоотой шийдвэрийг цахим хуудсанд байршуулаагүй 17 байгууллагын 427 тушаал.

Шилэн дансны хууль, журмын хэрэгжилтэд хийсэн үзлэг шалгалтаар зарим нэг алдаа дутагдал гарч байгаа нь Сангийн яамнаас шилэн дансны нэгдсэн <http://shilendans.gov.mn/> цахим хуудсыг шинэчилсэн, шинэ тутам хэрэгжиж байгаа хууль, журам учраас ойлголтын зөрүү үүсэх, эрх зүйн актыг буруу ташаа ойлгох гэх мэт санаатай бус алдаа дутагдлаас үүдэлтэй гэж дүгнэсэн.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн 2015 оны үзлэг шалгалтын дагуу цаашид дараах арга хэмжээг авч ажиллахаар төлөвлөсөн. Үүнд:

- 2015 оны Шилэн дансны дутуу байршуулсан мэдээллийг ойрын хугацаанд нөхөж оруулахыг нийслэл, дүүргийн харьяа байгууллагын удирдлагуудад үүрэг болгох;
- Шилэн дансны тухай хуулийн 10.1. "Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. /...үүнийг 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө." заалтын дагуу 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хариуцлага хүлээлгэх хугацаа хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан Нийслэлийн удирдах ажилтны шуурхай хурлаар Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулж ажиллахыг байгууллагын удирдлагуудад үүрэг болгох;
- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын зарим зүйл заалт нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэхгүй байгаа болон мэдээлэл оруулах, хянахтай холбоотой тулгарч байгаа асуудлуудыг нэгтгэн Сангийн яаманд албан бичгээр хүргүүлэн тодруулга авах;
- НАГ-аас нийслэл, дүүргүүдийн ТЕЗ нарт ирүүлсэн албан шаардлага, Шилэн дансны тухай хуулиар хүлээлгэх хариуцлага, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэлийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын шилэн данс хариуцсан албан тушаалтнууд, дүүргүүдийн Дотоод аудитын албаны мэргэжилтнүүдэд сургалт явуулах.

2. 2016 оны эхний хагас жилийн үзлэг шалгалт

Шилэн дансны тухай хууль, журмын 2016 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн үзлэг шалгалтыг 2016 оны 9 дүгээр сарын 22-ний өдрөөр тасалбар болгон хийж дүнг нэгтгэн тайлагнасан. Шалгалтаар дараах алдаа зөрчил илэрсэн. Үүнд:

2.1 Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)

нийслэлийн харьяа 66 байгууллагын 39 мэдээллээ байршуулан, 27 байгууллага 2017-2019 оны төсвийн төслийг байршуулаагүй байна. Үүнд:

- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
- Нийслэлийн Засаг даргын тамгын газар
- Улаанбаатар хотын музей
- Монгол Улсын хүүхэд, гэр бүл хөгжлийн Өнөр бүл төв
- Нийслэлийн архивын газар
- Нийслэлийн Авто замын газар
- Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв НӨҮГ
- Нийслэлийн Мэдээлэл технологийн газар
- Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар
- Нийслэлийн Гэр хорооллын хөгжлийн газар
- Нийслэлийн Ахмадын хороо
- Нийслэлийн онцгой комисс
- Бэлчээрийн менежмент төслийн нэгж УТҮГ
- Нийслэлийн Усан спорт сургалтын төв
- Нийслэлийн Авто худалдааны цогцолбор ОНӨААТҮГ
- Хүнс хангамж төв ОНӨААТҮГ
- Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ
- Багачууд хүнс ОНӨААТҮГ
- Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар
- Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл ОНӨААТҮГ
- Нийслэлийн Гэр хорооллыг орон сууцжуулах төсөл
- Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ
- Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих, хөтөлбөр төсөл
- Улаанбаатар лифт НӨҮГ
- Багахангайн мах боловсруулах үйлдвэр НӨҮГ
- Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ
- Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ

2.2 Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)

Шилэн дансны тухай хуулийн 6.1.2. “хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;” мэдээлнэ заалтыг төсөвт 44 байгууллага хэрэгжүүлэн ажилласнаас 66.1 хувь нь мэдээллийг хугацаанд нь, 33.9 хувь нь хугацаа хоцроон мэдээллэсэн байна.

2.3 Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)

Шилэн дансны тухай хуулийн 6.4. “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.” 6.4.1. “тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт;”-ийг мэдээлнэ заалтын дагуу тус маягыг

төсөвт 44, ОНӨААТҮГ 23 нийт 66 байгууллага хөтлөхөөс 53 байгууллага хугацаандаа, 13 байгууллага хугацаа хоцроож шивсэн байна.

2.4 Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)

Нийт 66 байгууллага 417224.5 сая төгрөгийн орлогын гүйлгээ, 272527.3 сая төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээллэсэн байна. Мэдээлэл оруулахдаа нийт байгууллагын 65.2 хувь нь хугацаандаа, 34.8 хувь нь хугацаа хоцроож мэдээллэсэн байна.

Бусад цэсэнд байршуулах мэдээллийг хугацаандаа оруулсан эсэх талаар доор харуулав. Үүнд:



Шилэн дансны тухай хууль, журмын 2016 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн үзлэг шалгалтаар дараах зөрчлийг илрүүлж тухай бүр залруулуулсан. Үүнд:

- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг байршуулаагүй 13 байгууллагад
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 10 байгууллагын нийт 7238.7 сая төгрөгийн 136 гүйлгээг;
- Нийт 6 байгууллагын 388525.3 сая төгрөгийн 9 тендерийг;
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг 10 байгууллагын 787.8 сая төгрөгийн гүйлгээг;
- Дараа жилийн төсвийн төслийг 11 байгууллага;
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг 14 байгууллага;
- 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг оруулаагүй болон буруу бөглөсөн байгууллагуудыг нөхөн оруулуулан ажилласан;

- Байгууллагын өмч хөрөнгөтэй холбоотой шийдвэрийг цахим хуудсанд байршуулаагүй 12 байгууллагын мэдээллийг байршуулуулсан.

2.3. ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ТАЛААР:

Чанарын хяналтын баг нь хэлтсийн дарга Д.Нансалмаа, аудитор П.Батбилэг, шинжээч Т.Ариунцэцэг нарын бүрэлдэхүүнтэйгээр Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаа, санхүүгийн тайланд хийсэн гүйцэтгэлийн болон санхүүгийн төлөвлөгөөт аудит, сэдвийн аудит, захиалгат аудит, зөвлөмж хэрэгжилтийг нэгтгэх, 2017 оноос мөрдөх эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох, чанарын хяналтын хуудас бэлтгэх, чанарын хяналтын ажлын баримтыг шинэчлэн мөрдүүлэх, албаны аудитор, шинжээч нарын чанарын баталгаажуулалт, сайжруулах хөтөлбөрийг боловсруулах, сургалт сурталчилгаа, олон нийтийн ажлын хүрээнд дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Дотоод аудитын гарын авлагын хавсралт 1001-4005 аудитын ажлын баримтуудыг нэг стандарт, загварт оруулж, байгууллагын даргын 2016 оны А/02 дугаар тушаалаар батлуулж, улсын салбарын дотоод аудитад хөтлөвөл зохих дараахь ажлын баримтуудыг аудит хийсэн байгууллага, ажил нэг бүрээр хөтөлж баталгаажуулан аудитын материалд хавсаргадаг боллоо. Үүнд:

1. Дотоод аудитын ажлын тайлан /Ажлын баримт 3001/
2. Аудитаар илэрсэн асуудлын бүртгэл /Ажлын баримт 3002/
3. Аудитаар илэрсэн асуудлын жагсаалт /Ажлын баримт 3003/
4. Удирдлагын хариу арга хэмжээний төлөвлөгөө /Ажлын баримт 3004/
5. Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн мөрөөр эргэн хянах горимын хуудас /Ажлын баримт 4001/
6. Аудитын дуусгалтын шалгах хуудас /Ажлын баримт 4002/
7. Дотоод аудитын ажлын тайланг шалгах хуудас /Ажлын баримт 4003/
8. Аудитын гүйцэтгэлийг үнэлэх хуудас /Ажлын баримт 4004/
9. Аудиторын ажлын гүйцэтгэлийг үнэлэх хуудас /Ажлын баримт 4005/

- Хэлтсийн аудитор, шинжээч нар 2015 онд хийсэн аудитын нэг сайн тайлангаа хамт олны хуралд танилцуулан, харилцан ярилцлага хийсний үр дүнд хэлтсийн аудитын тайлан, хөтөлбөрийг нэг стандартад оруулах загварыг 2 хувилбараар боловсруулж хэлэлцүүлэн, байгууллагын даргын 2016 оны А/09 дүгээр тушаалаар батлуулан мөрдөж байна.

- 2016 онд 32 байгууллагад гүйцэтгэлийн болон санхүүгийн аудит хийж нийт 11190.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж 263 зөвлөмж хүргүүлсэн. Дээрх зөвлөмжүүдийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Тухайлбал:

Санхүүгийн аудитад 2016 онд нийт 11 байгууллага аудитад хамрагдаж, 54 зөвлөмж өгч ажилласнаас хугацаандаа хэрэгжсэн 28, хугацаа болоогүй 19, хугацаандаа хэрэгжээгүй 7 зөвлөмж байна. Мөн 4,495.7 мянган төгрөгийн акт төлөгдөөгүй байна.

Гүйцэтгэлийн аудитад нийт 21 байгууллага хамрагдаж, 192 зөвлөмж хүргэгдэж, хугацаандаа хэрэгжсэн 153, хугацаа болоогүй 52, хугацаандаа хэрэгжээгүй 4 зөвлөмж байна.

- Албаны дотоод хяналтын систем, эрсдэлийн удирдлагын тогтолцоог үр өгөөжтэй үр нөлөөтэй ажиллуулах, боловсронгуй болгох талаар зөвлөмж өгч, хэрэгжилтийг ханган ажиллах зорилгоор нийслэлийн Засаг даргын хамрах хүрээний байгууллагуудын эрсдэлийн шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж, үзүүлэлтүүдийг шинэчилсэн бөгөөд 2017 оноос байгууллагуудын эрсдэлийг шинэчилсэн үзүүлэлтээр үнэлнэ.

- Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын дотоод аудитын нэгж, дотоод аудиторуудын нэгдсэн судалгааг шинэчлэн гаргаж, хамрах хүрээний байгууллагуудын дотоод аудиторуудад байгууллагын үйл ажиллагаанд гардаг нийтлэг алдаа дутагдалын талаар сургалт, семинар зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан. Энэ ажил цаг үеийн байдлаас болж хойшилсон.

- Албан хаагчдын сургалтын хэрэгцээ, шаардлагыг судалгаагаар тодорхойлж, байгууллагын 2016 оны сургалтын төлөвлөгөөг гаргаж, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон.

2017 оны 01 дүгээр сарын 11